

БСБ - Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр – Хаан Банк II

Улс:	Монгол
Төслийн дугаар:	54475
Бизнесийн салбар:	Санхүү (банк)
Мэдээллийн төрөл:	Хувийн хэвшил
Байгаль орчны ангилал:	
Хэлэлцэх хурлын огноо:	2023 оны 04 дүгээр сарын 18
Төлөв байдал:	Судалгааны түвшинд, Эцсийн хяналт хүлээгдэж байгаа
Төслийн Хураангуй баримт бичиг /ТХББ/:	

Төслийн танилцуулга

Төв Азийн Бизнес эрхлэгч Эмэгтэйчүүдийг дэмжих Хөтөлбөр (ТА БЭЭДХ)-ийн хүрээнд 20,000,000 ам.доллар хүртэлх 3 жилийн хугацаатай анхдагч өглөгт тооцогдох зээлийг Хаан Банк (ХБ)-нд олгох төсөл. Уг төслийн дижитал бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 5 сая ам.долларын зээлийг дижитал шилжилтийн хөрөнгө оруулалтанд зориулж олгоно.

Төслийн зорилго

Дотоодын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, эмэгтэй бизнес эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд төслийн зорилго оршино.

Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл (ХШН)-ийн оноо: 70

Энэхүү төсөл нь Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөрт хувь нэмрээ оруулан, Тэгш оролцоо ба Өрсөлдөх чадварыг бий болгохыг дэмжинэ. Тус зээл нь эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг дэмжихийн зэрэгцээ "санхүүгийн хүртээмж" ба "ажил эрхлэлт, бизнес эрхлэлт"-ийн жендерийн дутагдлуудыг багасгаж бизнесийн орчинд эмэгтэйчүүдийн идэвхитэй оролцоог дэмжинэ. Нэмж дурдахад ТА БЭЭДХ-ийн дижитал бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд эмэгтэйчүүдийн эзэмшлийн БЖДҮ-ийн санал болгож буй үйлчилгээ, эзэмшиж буй хөрөнгө, хэрэгжсэн бизнесийн үйл явцыг дижитал шилжилтэнд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх болно.

Харилцагчийн мэдээлэл

Хаан Банк ХХК

ХБ нь Монгол Улсын хамгийн том арилжааны банк бөгөөд 545 салбар тооцооны төвөөр дамжуулан Монгол улсын хүн амын 82%-д үйлчилгээ үзүүлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт хөрөнгийн хэмжээ 4.3 тэрбум ам.доллар, зээлийн багцын хэмжээ 2.3 тэрбум ам.доллар, өөрийн хөрөнгийн хэмжээ 439 сая ам.доллар байна. ХБ одоогоор ЖДҮ-ийг аажмаар нэмэгдүүлэхэд чиглэсэн стратеги баримтлан ажиллаж байна. Тус банк Мүүдийс олон улсын үнэлгээний байгууллагаас “В3/тогтвортой” үнэлгээ болон Фитч агентлагаас “В/тогтвортой” гэсэн үнэлгээ авсан.

ЕСБХБ-ны санхүүжилтийн тойм

20,000,000.00 ам.доллар

20 сая ам.доллартай тэнцэх анхдагч өглөгт тооцогдох зээл

Төслийн нийт өртөг

20,000,000.00 ам.доллар

20 сая ам.доллартай тэнцэх анхдагч өглөгт тооцогдох зээл

Байгаль орчин, нийгмийн тойм

Санхүүгийн зуучлагчид - ангилал (2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлого баримт бичиг). Хаан банк ХХК нь ЕСБХБ-ны харилцагч бөгөөд өмнө нь баримталж буй бодлогын дагуу Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн журмыг нэвтрүүлж 2,4,9-р Гүйцэтгэлийн шаардлагуудыг хангасан. ХБ дээрх шаардлагуудыг ЕСБХБ-ны санхүүжилттай бүх дэд зээлүүдэд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, дэд зээлдэгч нарт Байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдлын стандартуудыг үргэлжлүүлэн мөрдүүлнэ. Харилцагч нь ЕСБХБ-ны байгууллага, ЖДҮ болон бичил зээлийн Байгаль орчин, нийгмийн журмыг баримталж Байгаль орчин, нийгмийн үл зөвшөөрөх жагсаалт болон Гүйцэтгэлийн шаардлага 9-д заасан лавлагааны жагсаалтыг дагаж мөрдөнө. ХБ нь 2,4,9-р Гүйцэтгэлийн шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг баталгаажуулан, жил бүр байгаль орчин, нийгмийн тайлан илгээх шаардлагатай.

А. Техник хамтын ажиллагаа /ТХА/

1. Техник хамтын ажиллагаа /ТХА/

ТА БЭЭДХ-ийн хүрээнд олгогдох ТХА нь дараах хоорондоо хамааралтай хоёр хэсгээс бүрднэ.:

(i) Харилцагч санхүүгийн зуучлагч байгууллагуудад (ХСЗБ) зориулсан чадавхи сайжруулах хөтөлбөр: Тус ТХА-ны хөтөлбөр нь 8 сая ам.доллар хүртэлх хэмжээтэй бөгөөд ХСЗБ-уудын чадавхийг сайжруулах, хөтөлбөрийг дэмжихэд зориулагдана (ХСЗБ тус бүр ойролцоогоор 300-400 мянган ам.доллар). ТХА-ны хөтөлбөр нь ХСЗБ-уудад эмэгтэйчүүдийн эзэмшдэг ЖДҮ-ийн онцлог хэрэгцээнд нийцсэн санхүүгийн бүтээгдэхүүн, зээлийг тус тусад нь хөгжүүлэхэд туслахыг зэрэгцээ ХСЗБ-ын ажилтнуудыг сургах, маркетингийн дэмжлэг үзүүлэх, түүнчлэн энэ бүлэгт зээл олголтыг тогтвортой болгохын тулд тодорхой зах зээл дэх алдаа дутагдалд

анхаарлаа хандуулах замаар эрсдэлийг хуваалцан хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжнэ. ТХА нь ХСЗБ-ыг эмэгтэйчүүдийн эзэмшдийн ЖДҮ-ийн харилцагч нарт дижитал шилжилтэнд зориулсан хөрөнгө оруулалтыг сурталчлах, үнэлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ уг төслийн шинэ дижитал бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд санхүүгийн урамшууллын системийн хэрэгжилтийг дэмжинэ.

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi

Дүн/валютын төрөл: ТА БЭЭДХ-н төвшинд 5.25 сая ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

Харилцагчийн оруулах хувь: ЕСБХБ-ны Харилцагчийн оруулах хувь нэмрийн талаар баримтлах бодлого (BDS20-119/Rev 1) болон удирдамжийн дагуу, ХБ нь ТХА-г дэмжихийн тулд 28,000 ам.доллар хүртэлх хувь оруулах шаардлагатай болно. Энэхүү хувь хэмжээнд БЭЭДХ-тэй холбоотой бүтээгдэхүүний сургалт семинар явуулах, сурталчлах арга хэмжээ, маркетингийн үйл ажиллагаа болон материалуудыг оруулж болно.

ii) Зөвлөх Үйлчилгээ Хөтөлбөрөөр дамжуулан эмэгтэйчүүдийн эзэмшлийн ЖДҮ-ийн чадавхийг сайжруулах хөтөлбөр

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi

Дүн/ валютын төрөл: Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн төвшинд 5.7 сая ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

Б. Хамтарсан хөрөнгө оруулалтын буцалтгүй тусламж / Хөнгөлөлттэй санхүүжилт (ТХА бус)

i) БЭЭДХ II зээлийн 10 хүртэлх хувийг (нэг дэд зээл тутамд 70% хүртэлх) эрсдэлийн анхны даатгалд (FLRC) хамруулна. Эрсдэлийн анхны даатгал нь уг хөтөлбөрт хамрагдсаны үр дүнд ХБ-д зээлийн алдагдал байгаа тохиолдолд нөхөн олгоно.

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi болон SBIF

Дүн/ валютын төрөл: Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн төвшинд 7.2 сая ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

ii) Дэд зээлдэгч нарт олгох **санхүүгийн урамшууллын систем** - олгосон дэд зээлийн хамгийн багадаа 10%-д эсвэл **дижитал бүрэлдэхүүн хэсгийн дагуу** 30,000 ам.доллар олгоно.

Санхүүжилтийн эх үүсвэр: We-Fi

Дүн/ валютын төрөл: Төв Азийн Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн Хөтөлбөрийн төвшинд 3 сая ам.доллар

Санхүүжилтийн төлөв: Батлагдсан

Нэмэлт ашиг тус

Санхүүжилтийн бүтэц: ЕСБХБ нь зах зээл дээр санал болгож байгаагаас урт хугацаанд эргэн төлөгдөх зээлийг боломжийн нөхцөлөөр санал болгодог.

Мэдлэг, инновац, ба чадавх сайжруулах: ЕСБХБ-аас харилцагч байгууллагад төслийн зорилгуудыг цаг тухайд нь биелүүлэхэд шаардлагатай чухал чадварууд

болох туршлага, инновац, болон мэдлэгээр хангана. Үүнд үйлчлүүлэгчийн чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Холбоо барих хүний мэдээлэл

Б.Эрдэнэдэлгэр, Хөрөнгө зохицуулалт хариуцсан захирал

erdenedelger.b@khanbank.com

+976 11 332 333

+976 70 117 023

www.khanbank.com

Хаан Банк ХХК, Сөүл гудамж-25, ш/х #192, Улаанбаатар, Монгол Улс

Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: projectenquiries@ebrd.com

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: procurement@ebrd.com

Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах

механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд compliance@ebrd.com цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алианаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)–ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол ipam@ebrd.com цахим шуудангаар хандаж болно.